

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2015 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг тус байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хэлэлцээд дараах санал дүгнэлтийг гаргаж, Та бүхэнд танилцуулж байна.

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийн 6 бодлого, 25 зорилт, 104 арга хэмжээний биелэлт 2014 оны жилийн эцсийн байдлаар 63.7 хувьтай гарсан байна.

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах "Макро эдийн засгийн бодлого"-ын хэрэгжилт 55.4 хувьтай гарчээ.

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Үндсэн чиглэлийг хэлэлцэхэд зарим асуудлуудыг тодруулах, дүгнэлт хийх шаардлагатай, цаашид Үндсэн чиглэлд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг тусгах уу, эсвэл хамтарсан гээд өөр хөтөлбөр хэрэгжүүлэх үү гэдгээ тохирох хэрэгтэй, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, намуудын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрийг харьцуулж дүгнэлт гаргах хэрэгтэй, Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол Засгийн газраас төлөвлөгдсөн 1.6 жилд хийгдэх ажлуудыг цаашид Үндсэн чиглэлд тусгах, мөн эдийн засгийн хямралаас шалтгаалан хөрөнгө оруулалтын ажлууд хугацаандаа хийгдэхгүй байгаа тул Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс санхүү, хөрөнгөөс шалтгаалан хэрэгжих боломжгүй заалтуудыг хасаж өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хороо "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг хэлэлцээд гаргасан санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгагдсан асуудлуудыг Улсын Их Хурлаас гарах шийдвэрийн төсөлд тусгаж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.БОЛОР

